НОГООН ХӨГЖЛИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ КОНТЕНТУУД БОЛОН АППЛИКЕЙШН ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр: Ногоон хөгжлийг түгээн дэлгэрүүлэх контентууд болон апп хөгжүүлэх ажил

Үндэслэл

- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 12, 13, 17 зорилтууд Монгол улсын Алсын хараа 20-50, МУЗГ-ын мөрийн хөтөлбөрт цөлжилтийг бууруулах, хүнсний хангамж, шим тэжээлийг нэмэгдүүлэх, ногоон хөгжлийг өрнүүлэх шийдвэрүүд тусгагдсан,
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд таригдаж буй мод бутны нилээдгүй хувь нь говийн бүс нутагт, цөлжилтийг бууруулах, уул уурхайн нөхөн сэргээлт, аймаг сумын төвүүдийн нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн байгуулахад чиглэгдэж, шинэ техник технологи ноу хауг хэрэгжүүлж байна.
- Дэлхий нийтээр хүнсний хангамж, тээвэр ложистикын байдал хүндэрсэнтэй холбоотойгоор манай улс дотооддоо Хүнсний хувсгал хөдөлгөөн өрнүүлж, хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг хэрэгжүүлж эхлээд байна. Дулаан улирал ихтэй говийн бүс нутгуудаар 4 улирлын хүлэмж барих, хүнсний нарийн ногоо тариалах хандлага ихсэж байна. Өрх бүр өөрсдийн хүнсний асуудлаа шим тэжээл бүхий шинэхэн ногоогоор хангах хандлага төлөвшиж байна.
- Өмнөговь аймгийн ЗД-ын "Нутгийн хишиг" мөрийн хөтөлбөрт тусгагдсан говийн бүсэд ногоон хөгжлийг түгээн дэлгэрүүлэх, цөлжилтийг бууруулах, Говь-ус, Цахим жишиг аймаг, Цэгцтэй гэр хороолол, Хашаандаа сайхан амьдрая, Нутгийн үйлдвэрлэгч зэрэг иргэдийн амьжиргааны бодит өсөлтийг авчрах төслүүд хэрэгжиж байна.
- Монгол улсын Засгийн газраас мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэдийн оролцоо, санал хүсэлтийг авах механизмыг сайжруулах, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, бүтээмжтэй болгор "Ухаалаг засаг", Цахим аймаг болох төсөл хэрэгжиж байна.

Зорилго

Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд суурилан тогтвортой хөгжилд хүрэх урт хугацааны зорилго, үйл ажиллагааг хэрхэн бодитоор хэрэгжүүлж байгаа туршлагыг түгээн дэлгэрүүлэх, аймгийн нутаг дэвсгэр дэх ургуулсан бүтээн байгуулалтын үр дүн, ач холбогдол, ноу хауг системтэйгээр мэдээллэх, иргэд олон нийтийн санал санаачлагыг дэмжих, тэднийг мэдлэг мэдээллээр хангах гүүр болох апп хөгжүүлэх, нэгдсэн портал дээр контент үйлдвэрлэж байршуулах,иргэд ААН байгууллага өөрсдийн үйл ажиллагааг амар хялбар байдлаар оруулдаг талбар бий болгох

Төсөл хэрэгжсэнээр гарах үр дүн:

- "Цахим жишиг аймаг" концепцийн хэрэгжилтэнд хувь нэмэр оруулна.
- Иргэд нэг сувгаар дамжуулан Өмнөговь аймаг дахь ногоон хөгжил, мод ургамал, хүнсний ногоо, газар тариалангийн мэдлэг, мэдээлэл, үйлчилгээ системтэйгээр дэмжлэгийг цахим хэлбэрээр авах боломж бүрдэх;
- Иргэд өөрсдийн тарьж ургуулсан зүйлийг борлуулах, худалдан авах, үйлчилгээний төлбөр төлөх, туршлага солилцох мэдээлэл авах боломж бүрдэнэ;
- Эрдэмтэн судлаачид, туршлагатай ургуулагчдын блогоор дамжуулан туршлагыг иргэд, ААН, байгууллагуудад түгээн дэлгэрүүлэх
- Засаг даргын мөрийн хөтөлбөр дахь бодлого үйл ажиллагааны хүрээнд ногоон хөгжлийн ажлууд болон дэмжлэгийг нэг сувгаар авах

- Хэл яриа, бичгийн харилцааны чадавхи (тодорхой ойлгомжтой ярих, бичих, тайлбарлах, гэрээ байгуулах, хүмүүстэй харилцах)
- Төлөвлөх зохион байгуулах, биелэлтийг хангах чадавхи

UI, UX дизайнер

- UI График дизайн эсвэл мэдээллийн технологи чиглэлээр төгссөн
- Мэргэжлээрээ 2-с дээш жил ажилласан туршлагатай
- Adobe Creative Suite, Sketch, Visio болон бусад шаардлагатай программуудыг эзэмшсэн
- HTML, CSS (SCSS) мэдлэгтэй.
- UI/UX дизайны өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагыг сонирхон судалдаг
- Branding бүтээх, Brand book хөгжүүлэх тал дээр тодорхой ажил хийж байсан болон тухайн чиглэлээр сонирхон судалдаг.
- UI гаргахад шаардлагатай програмууд дээр ахисан түвшинд ажиллах чадвартай /Adobe collection + Visio/.
- Бизнес анализ хийх, дүгнэлт гаргах чадвартай
- Англи хэлний мэдлэгтэй.
- Судалгаа хийх, шийдэл олох, шийдвэр гаргах чадвартай
- HTML, CSS болон Framework мэдлэгтэй.

Программ хангамжийн зөвлөх

- Мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэг эзэмшсэнКомпьютер график дизайнер, дүрслэх урлаг болон арт чиглэлээр бакалаврын зэрэгтэй эсвэл түүнтэй адилтгах ажлын туршлагатай
- Десктоп болон хөдөлгөөнт төхөөрөмжүүдэд зориулсан UX/UI дизайны
- ажлын жишээг агуулсан портфолио хийж байсан туршлагатай
- Adobe CS-ийн ур чадвар (InDesign, Illustrator, Photoshop)
- Microsoft Office (Word, PowerPoint, Excel) болон iWork (Үндсэн
- тэмдэглэл, хуудас, тоо) программыг эзэмшсэн.
- Дижитал/интерактив хэрэгслүүд (жишээлбэл, Adobe DPS, интерактив
- PDF, AfterEffects, Articulate гэх мэт) боловсруулах чиглэлээр эжиллаж байсан
- Motion график, 3D видео хийх чадвартай бол давуу тал болно.
- Бүтээлч сэтгэлгээтэй, өөр өнцгөөс харж шийдлүүд санал болгодог.
- Аливаа мессежийг контентын төрлүүдээр (зураг, видео г.м) илэрхийлэх чадвартай
- Видео моушн програмууд дээр ажиллах чадвартай.
- Программ хангамж хөгжүүлэлт, өгөгдлийн менежментийн чиглэлээр 3- аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх.
- Амжилттай хэрэгжсэн программ хангамжийн төсөлд гүйцэтгэх түвшид
- ажилласан байх.
- Англи хэлний мэдлэгтэй, ярианы болон бичгийн чадвар эзэмшсэн байх.
- Брэндийн ялгамжийг хадгалж, үүнд тохирсон артууд гаргах чадвартай.

График дезайнер

- Photoshop, InDesign Quark, Illustrator зэрэг программуудыг эзэмшсэн байх.
- Бүтээлч сэтгэлгээтэй, уран зургийн авъяас чадвартай
- Цагийг үр дүнтэй удирдах ур чадвар, эцсийн хугацааг биелүүлэх чадвар.
- Бүтээлч шүүмжлэл өгөх, хүлээн авах чадвартай.

- Маркетинг, үйлдвэрлэл, вэб сайтын дизайн, байгууллагын брэндинг, бүтээгдэхүүний сав баглаа боодол, зар сурталчилгааны концепци гаргах чадвартай.
- График дизайнер нь креатив сэтгэлгээтэй, харилцагчид анхаарал хандуулах ур чадвартай, асуудлын агуулга мөн чанарыг ойлгох, бүтээлч, уян хатан сэтгэхүйтэй

Жиргэх
Хуваалцах

- Цахим хэлбэрээр мод тариулах захиалга өгөх ажиллагааг Монгол орны иргэдэд хүртээмжтэй байдлаар зохион байгуулж, мод захиалах, төлбөр төлөх, тариулсан модны арчлагааны процессыг хянах боломжтой болох

Хамрах хүрээ: Өмнөговь аймгийн иргэд, ААН, байгууллагууд
Оролцогсод: Говийн бүсэд мод, ургамал, ногоо тарих арга аргачлал, техник технологи нэвтрүүлэгч ААН, байгууллага, эрдэмтэн, судлаачид, айл өрх, бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи нэвтрүүлэгчид, иргэд

Төсөл хэрэгжих үе шат:
- Контентын агуулга боловсруулах, контент үйлдвэрлэх
- Техникын шаардлагын дагуу аппликейшн хөгжүүлэх
- Контентыг нэгдсэн порталд байршуулах, контент, мэдлэг, мэдээллийг орон нутгийн сошиал сувгууд, ТВ суваг болон нээлттэй өдөрлөгүүдээр дамжуулан олон нийтэд түгээж, иргэдийн оролцоог хангах гэсэн 3 үе шаттайгаар хэрэгжинэ

Хаана хэрэгжих: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт.
Төслийн захиалагч байгууллага: Өмнөговь аймгийн Засаг даргын тамгийн газар

Зөвлөх компанид тавигдах шаардлага:

- Төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа, түүний шат дамжлагын талаар ойлголт, мэдлэгтэй байх.
- Онлайн платфор, аппликейшн хийж, хэрэгжүүлж байсан туршлагатай.
- Онлайн үйлчилгээ болон маркетингийн контент үйлдвэрлэх туршлагатай боловсон хүчинтэй байх эсвэл туршлага бүхий этгээдтэй гэрээ хийсэн байх.
- Ногоон бизнес, мод ургамлын чиглэлээр мэдлэгтэй мэргэжилтэнгүүдтэй, агуулга боловсруулах ур чадвартай, контент, аливаа бүтээл хийсэн туршлагатай.
- Маркетингийн контентыг видео, бичмэл, зурагт хуудас, сошиал пост хэлбэрээр боловсруулах чадвар, туршлагатай байх.

Гүйцэтгэгч нь багадаа дор дурдсан чадвар бүхий гишүүдээс бүрдсэн баг бүрдүүлсэн байна. Үүнд:
Ахлах зөвлөх, маркетер

- Мэдээллийн системийн чиглэлээр техникийн туслалцаа үзүүлж байсан туршлагатай байх,
- Төслийн менежментийн туршлагатай байх
- Холбогдох талуудын ажлын уялдааг хангах, мэдээллээр хангах, хамтран ажиллах харилцааны удирдах ур чадвартай, асуудал шийдвэрлэх чадвар эзэмшсэн байх;
- Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, асуудалд дүн шинжилгээ хийх өндөр ур чадвартай, төрийн бодлого боловсруулах түвшинд ажиллаж байсан туршлагатай.
- Контентын агуулга боловсруулах, персона тодорхойлох, контент марктинг, нейро маркетингийн зохих мэдлэгтэй байх.
- Тайлагнах, бусдад ойлгуулах, илтгэх, харилцааны өндөр чадвартай байх.
- Аналитик, логик сэтгэлгээтэй мэдээлэл дата цуглуулах, контентын агуулга боловсруулах ур чадвартай.
- Бүтээлч сэтгэлгээ (шинэчлэн сайжруулах, шинийг зохиомжлох, зургаар илэрхийлэх, оновчтой шийдэл сонгох, үр дүнг хүргэх г.м)

Хийгдэх ажлууд, үзүүлэлтүүд

№	Хийгдэх ажил	Үзүүлэлт	Тайлбар
	Даалгавар 1: Нэгдсэн портал сайтуудад байрших Өмнөговь аймгийн ногоон хөгжлийн мэдлэг мэдээллийг системтэйгээр оруулах нэмэлт цэс, дизайн, техникийн тодорхойлолтыг боловсруулах,	Шинэ өнгө төрх, орчин үеийн технологи ашигласан нэгдсэн удирдлагын системтэй Монгол хэлээр Суурин компьютор, Нөөтбүүк, Таблэт, Гар утас зэрэг төхөөрөмжүүдийн бравсоруудыг ашиглан мэдээллийг хаанаас ч оруулдаг байх	Бүх төрлийн ухаалаг утас, төхөөрөмж дээр ашиглах боломжтой Цаг үеийн, улирлын чанартай мэдлэг, мэдээлэл, контентуудыг хялбар байдлаар байршуулах боломжтой байх
			1. Ногоон хөгжил булан Аймгийн хэмжээнд ногоон ирээдүй, ногоон хөгжил, мод ургамлын чиглэлд нэвтэрсэн инноваци, технологийг иргэдэд түгээн дэлгэрүүлэх 20 аас доошгүй видео болон бичмэл хэлбэрийн контент үйлдвэрлэх 2. Говийн бүсийн онцлог эмийн ургамал тарьж ургуулж боловсруулж бүтээгдэхүүн хийж байгаа туршлага, арга технологийн талаар видео болон бичмэл 5 аас доошгүй контент үйлдвэрлэх 3. Хүнсний хангамж, шим тэжээл өрхийн АА, хүнсний ногоо, цэгцтэй гэр хороолол төслийн хүрээнд амжилттай ажиллаж байгаа айл өрхийн тухай видео болон бичмэл хэлбэрээр 20-оос доошгүй контент үйлдвэрлэх

	Даалгавар 2: Аймгийн төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, ААН байгууллагуудын ногоон ирээдүйд чиглэсэн ногоон хөгжлийн үйл ажиллагаа, ноу хау, мэдлэг мэдээллийн агуулга боловсруулах контент хийх	Өмнөговь аймгийн иргэд, ААН байгууллагууд өөрсдийн мэдээллийг амар хялбар байдлаар тогтмол мэдээллээ оруулдаг боломжийг бүрдүүлсэн байх Хэрэглэгчийг болон гар утасны аппликейшнийг бүрэн удирддаг байх	4. “Хашаандаа сайхан амьдаръя” аяныг өрнүүлж хороо, багийн айл өрхүүдийн хашаандаа ая тухтай сайхан амьдрах дэд бүтцээр хангах, ашигт ургамал, жимс жимсгэний мод, бут тариалахыг дэмжсэн ажлын талаар видео болон бичмэл 5 аас доошгүй контент үйлдвэрлэх 5. Ногоон хэрэм санаачлагын менежментийг сайжруулан, талуудын оролцооны зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, заган ойг хамгаалах, нөхөн сэргээх, таримал ойн талбайг нэмэгдүүлж, арчилгаа хамгаалалтыг сайжруулах ажлын талаар видео болон бичмэл хэлбэрээр 10-оос доошгүй контент бэлтгэх 6. Говийн бүсийн усны нөөцийг нэмэгдүүлэх судалгаа, зөв оновчтой шийдлийн талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бүтээх 7. Говийн бүсийн уур амьсгал, хөрс, ургамалд тохиромжтой туршигдсанмод ургамлын тэжээл, бордооны тухай видео болон бичмэл хэлбэрээр 10-аас доошгүй контент бэлтгэх| 8. Аймагт ногоон хөгжлийн шийдэл, санал санаачлага гаргасан 5-аас доошгүй эрдэмтэн, мэргэжилтэний блогийг видео болон бичмэл хэлбэрээр 20-оос доошгүй тоогоор бэлтгэх 9. Тэрбум мод, үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Ойн анги бусад иргэд, ААН, байгууллагуудын тарьсан модны байршил, цаашид тарих модны төлөвлөгөө, тарьж ургуулсан арга аргачлал, туршлага, ноу хауны талаар видео болон бичмэл хэлбэрээр 20-оос доошгүй контент бэлтгэх

			10. Ургамал хамгаалал, хөрс хамгаалалын чиглэлээр нэвтрүүлсэн тэргүүн туршлага ноу хауг түгээн дэлгэрүүлэх видео болон бичмэл хэлбэрээр 10-аас доошгүй контент бэлтгэх 11. Газар тариалан, хүнсний хувьсгал, тэрбум мод хөдөлгөөнийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн иргэд ААН-үүдэд хэрэгцээт техник, багаж хэрэгслийн талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 12. Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн Даланзадгад суманд "Агропарк" байгуулан мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжөөр хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн аймаг дотоодынхоо хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэгцээг хангах бодлого үйл ажиллагааны хүрээнд видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 13. Газар тариалан, мал аж ахуй хосолсон эрчимжсэн фермерийн загвар аж ахуй байгуулах санаачилгыг бодлогоор дэмжих үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх ажлын явцын талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 14. Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, хүнсний ногоог борлуулах "Өмнөговьд үйлдвэрлэв", " Өмнөговьд тарьж ургуулав" борлуулалтын цэгийг Өмнөговь, Улаанбаатар хотод бий болгож, баялаг бүтээгчид, малчдыг дэмжсэн үйл ажиллагааны талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 15. Залуучууд, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан технологи, инновацийн төв байгуулж, судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брендэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах ажлын талаар видео

			болон бичмэл хэлбэрээр 10-оос доошгүй контент бэлтгэх 16. Агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол, хөл ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийн талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 17. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 18. Уул уурхайн бүс нутгийн цөлжилтийг бууруулах орон нутгийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан ногоон байгууламжийн төслийг тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдтэй хамтран хэрэгжүүлж буй үйл ажиллагааны видео болон бичмэл хэлбэрээр 5-оос доошгүй контент бэлтгэх 19. Монголын говь, цөлийн экосистем, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, төлөв, үр нөлөөг судлах олон улсын судалгааны байгууллагыг дэмжиж, олон улсын говь судлалын чиглэлийн тогтмол үйл ажиллагаатай бүтэц бий болгох ажлын явцын талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх 20. Усны нөөц, сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, гадаргын усыг хуримтлуулж, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хамгаалах усны нөөцийн зохистой менежментын бодлого хэрэгжүүлж, ногоон бүс байгуулах санал санаачлагыг

			дэмжсэн үйл ажиллагааны талаар видео болон бичмэл хэлбэрээр 5-аас доошгүй контент бэлтгэх
	; Даалгавар 3: Аппликейшн хөгжүүлэх, удирдлагын систем	Тодорхой нэг байршилд цахим хэлбэрээр дэлхийн өнцөг булан бүрээс мод тарих байршлыг харах, сонгох, захиалга авах, төлбөр төлөх, өөрийн модыг хэрхэн ургаж арчилж байгааг хянах боломжтой байдлаар хөгжүүлэх	1. Мод тарьсан, тарих газрын мэдээллийг нэмдэг, засдаг, устгадаг 2. Шинээр мод тарих газруудыг нэмдэг, засдаг устгадаг 3. Хашааны газартаа болон хүлэмжинд хүнсний ногоо тарьж ургуулдаг иргэд, ААН байгууллагуудын мэдээллийг оруулдаг, нэмдэг, засдаг, устгадаг 4. Ногоон ирээдүйтэй холбоотой эвент арга хэмжээнүүдийг мэдээлдэг байх 5. Тухайн мод тарих ажиллагааг зохион байгуулж буй байгууллагатай холбогдож, модоо сонгож, төлбөрөө цахим хэлбэрээр хийж болдог, өөрийн модыг цахим хэлбэрээр хянаж болдог байдлаар хийх 6. Иргэд ААН өөрсдийн борлуулах мод, ургамал, хүнсний ногооны мэдээллийг оруулдаг, зарж борлуулдаг худалдаж авдаг 7. Говийн бүсэд ургадаг 10 аас доошгүй моднуудын гарын авлагыг аппликейшнд байршуулах
	Даалгавар 4: Боловсруулсан контентуудыг түгээх	Шаардлага хангасан контентууд, блог, мэдлэг мэдээллийг хийгдсэн байх	10 аас доошгүй сошиал сувгууд, 2-оос доошгүй орон нутгийн ТВ, FM радио, 2 оос доошгүй үндэсний ТВ, FM радиогоор дамжуулан түгээх
	Даалгавар 5: Вэб сайт болон апплейкшныг ашиглах гарын авлага, видео зааварчилга бэлтгэн байршуулах	Монгол хэл дээр, дэлгэрэнгүй тайлбартай байх	Апп дотроос танилцаж ашиглах боломжтой байдлаар байршуулах
		Иргэдийн хүлэмжид нарын ногоо, гадаа талбайд хүнсний ногоо, мод бут сөөг тарьж арчилж ургуулахад зориулсан	

	Даалгавар 6: Сургалт зохион байгуулах	практик сургалт зохион байгуулах, онлайн сургалт болгож байршуулах, цаасан гарын авлага гаргах	5 аас доошгүй удаа

АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Төсөл нь 3 үе шаттайгаар хэрэгжиж, үе шат бүрт тайлагнаж ажиллана.
1. Эхний үе шат 2023.05-10 сар Контентийн мэдээ, мэдээлэл дата цуглуулах, агуулга боловсруулах, оролцох сумд, эрдэмтэн мэргэжилтэн, ААН байгууллагууд, айл өрхүүд, орон нутгийн засаг захирагааны байгууллагуудын жагсаалт, зураг авалт хийх, мэдээлэл дата өгөх хугацаа, хариуцах хүнийг томилох, батлах; хар зураг авалт хийх, аппликейшн хөгжүүлж эхлэх
2. Хоёр дахь үе шат 2023.10- 2023.12 мэдлэг мэдээлэл боловсруулж, контент үйлдвэрлэх
3. Гурав дахь үе шат. Контент болон мэдээ мэдээлэл түгээн дэлгэрүүлэх, аппликейшн ашиглалтанд оруулах

Хянасан ХОХБХэлтэс О.Эрдэнэ-Өрнөх

Боловсруулсан: .....